

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

XXXVIII (412)

2014

(09-23)

ВАГИНДРА ХИЙГЭЭД МОНГОЛ БИЧГИЙН ХОЛБОЦУУД

*Г. Гантогтох. Монгол хэл, хэлшинжлэлийн
тэнхимийн багш доктор (Sc. D) профессор*

§ 1. Буриадын цанид хамба Доржийн Агваан (ᠪᠦᠷᠢᠠᠳᠠ ᠴᠠᠨᠢᠳ ᠬᠠᠮᠪᠠ ᠳᠣᠷᠵᠢ ᠶᠢᠨ ᠠᠭᠪᠠᠭᠠᠨ ngag dbang 1854-1938) лхарамба хэлбичгийн ухааны эрдэмтэдтэй зөвшилцөн байж⁷ зохиож "Буриадын шинэ үсэг" буюу "Вагиндрын үсэг"-ийг зохиож нийтлүүлэхдээ бичгийн зурлагын махбод болсон ацаг, гэдэс, шилбэ хийгээд монгол зурмын уламжлалыг өвлөхийн зэрэгцээ буриад аялгуунаа зохилдуулан үсгийн зурмыг шинэтгэн, ойрадын тод үсгээс үлгэрлэн эгшиг үсгийн дүрс ялган сэлбэж, орос латин үсэг лүгээ ижилсгэн эхэн, дунд, адагт дүрс хувилгахгүй хийгээд төвөд үсгийн адил их бага А-гаас бусдыг их бага үсэг хэмээн ялгахгүй бөгөөд, урт эгшиг, тагнайшсан гийгүүлэгчийг манж үсгийн дусал бинт талбин ялгаж, орос үгийг үсэгчлэн бичих галиг үсэг нэмсэн ба ер тухайн үеийн үсэг бичгийн ололт бүхнийг нийцүүлэн зохилдуулсан авиалбар зүйн зарчмыг баримталсан шинэ маягийн монгол бичиг болгосон байна"⁸.

Урьдын мэргэдийн заншлаар зохиогч өөрөө Агваан/тө. (ᠠᠭᠪᠠᠭᠠᠨ ᠲᠦ ᠡᠷᠬᠡᠲᠦ/len-ü erketü)/ гэсэн нэрээ самгардаар орчуулан Vāgindra гэж бичдэг байснаас уламжлан "Вагиндрын үсэг" хэмээн хожим алдаршжээ. Вагиндра үсэг бол монгол мэргэдийн зохион хэрэглэж ирсэн олон бичиг үсгийн нэг, аман аялгуунд тохируулан зохиосон монгол бичгийн маань нэгэн хувилбар билээ.

§ 2. Эдүгээ XXI зууныг хүртэл уламжилж ирсэн вагиндра үсгийн дурсгалууд

ХЭМЭЭВЭЭС

1905-1910 оны хооронд Санкт-Петербургт чулуун бар болон тусгай хэвлэлийн үсгээр цөөн хэдэн товхимол гаргажээ. Эдгээрээс одоо шинжлэх ухаанд мэдэгдээд байгаа нь:

1. Vagindra, Sine qaučin üsüg- ьd- ün ilyal terigüten-i bičigsen debter orosiba, 16 тал. (Хэвлэсэн он, цаг тодорхойгүй)
2. Moŋɣol Bur'ad šine üsüg orušiba, 1906. III. 3, 8 тал
3. Bur'ad xūr: Tūrūšīn depter: "Naraŋ gedeg moŋɣol bur'ad nom bišig γaryaxo oroŋ. P'e't'erbyrge xotodo, 1907. V. 23, 33 тал
4. Surgūlīn bagši Bayarto Waŋpilay, Lharamba Nagvaŋ Doržīn. Uxān huryaži sedxel hayžirūlxo üligernūd orošiba, Санктпетербург, 1907. 12. 20. 33 тал
5. Burxaŋ bagšīn gegēni xur'āngoy namtar bolon Buyanto xaŋ xūbūni namtar orošibay, Санктпетербург, 1906, 19 тал

⁷ Bur'ad šine üzügtü tārūlhaŋ zurneŋ toltο geži exilegdeheŋ aŋxaŋ debter orošibay, Санктпетербург, 1908, 27-р тал

⁸ Г.Гантогтох. Вагиндра үсэг, "Алтаргана -4, Буриад -Монголчуудын угсаа түүхийн зарим асуудал", Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэл, хэлсэн үг" УБ., 2001, 305-328-р тал

6. Bur'ad šine üzügtü tārūlhan zürnen tolto geži exilegdehen aḡxan debter orošibay, Санктпетербург, 1908, 27 тал
7. Buyanto хан xübün Saraḡ gereltü хан xübün хойори üliger. Санктпетербург
8. Uxāḡ huryaži sedxel hayžirūlxo huryalnūd orošibay. Санктпетербург, 1908, 23 тал
9. Orod Puškani zurasan altaḡ zagason ontoxo orošibay.
10. Moḡyol buryaad üsegey ceceglig gedeg debter orošiba, Санктпетербург, 59 тал
11. Н. Амагаевъ и Аламжи - Мэргэнъ Новый монголо-бурятский алфавить. Sine moḡyol bur'aad saḡan tolyoi
12. čono baatar Санктпетербург, 1910. 12 тал

Сурвалж бичгүүдийг эх бичгээр нь зураг татуулж хэвлүүлэх, галиглах кирилл хийгээд монгол бичгээр хөрвүүлэх зэрэг эх бичгийн нарийн чимхлүүр ажлыг эрдэмтэн Ё. Жанчив, Соёлмаа нар тус тус гүйцэтгэв. Монгол улсын эрдэмтэн Ё. Жанчивын 2010 онд хэвлүүлсэн "Вагиндра үсгийн дурсгалууд" хэмээх бүтээл⁹, БНХАУ-ын эрдэмтэн Соёлмаагийн "Вагиндра үсэг болон түүний сурвалж бичгийн судалгаа" хэмээх (Ph. D) докторын зэрэг горилсон бүтээл болно.¹⁰ Эдгээр судалгааны бүтээл вагиндра үсгийн судлалд үнэтэй хувь нэмэр оруулсан үүнд судалгаа шинжилгээний өгүүлэл бичих хэн боловч эх сурвалжаас эшлэн татаад, мөр дугаарыг нь тавих, жишээ авах, галигласан баримт бүрдүүлж өгснөөрөө эрхэм чухаг юм.

Вагиндра үсгээр нэг зуу гаруй жилийн тэртээ хэвлэгдэж байсан эх бичгүүдийг орчин үеийн судалгааны аргаар шинжиж хэвлүүлсэн эдгээр бүтээлүүдээс эшилж, вагиндра хийгээд монгол бичгийн үсгийн холбоцуудыг харьцуулан толилуулъя.

§ 3. Монгол үсгээр бичих горим Нийт монгол хэлний нутгийн аялгуунуудыг нэгтгэсэн монгол бичгийн хэлний хийсвэр тогтолцоог тэмдэглэх зориулалттай тул залгамал хэлний зүй тогтлоор зохицсон өвөрмөц зурлагатай. Үсэг бүхэн үгийн эхэн, дунд, адагт гурван газар орох зурлагын хувилбартай.

Үгийн эхэнд орвол титэмтэй, дунд орвол үндсэн махбодоороо, адагт сүүл, цацлага, орхицтой.

Энэ нь үгийн амин сүнсийг илтгэж байдаг утга зүйн учир холбогдолтой. Үүнийг Г. Энхтуулын "Монгол бичгийн орхиц үсгүүд" хэмээх өгүүллээс эшилж үзүүлэв.¹¹

Үлгэрлэвэл хар гэдэг үгийг дэвсгэрлэж бичвэл чимээний утгыг заах бөгөөд цацлага бичвэл өнгө, гингэр, залгавал харуулдаж хусах гэсэн утгатай болдог. Монгол бичиг орхиц үсгийн ачаар үгийн утгыг ялгаруулдаг төдийгүй монгол сэтгэлгээний нарийн нандин өнгө аясыг орхиц үсгийн тусламжтайгаар ялгаруулан илтгэж чаддаг байна. Жишээ нь:

qoyar keriy-e nisčü yabuyad nige-yi ben qar gekь гэхэд хар яр гэж хажиглах гэсэн утгыг дэвсгэр үсгээр

qoyar keriy-e nisčü yabuyad nige-yi ben qar-a gekь гэхэд нэгийгээ хар өнгө, зүстэй гэж басамжлах буюу хоёулаа адилхан байж нэгийнхээ харыг гайхах гэсэн утгыг цацлагаар

⁹ Ё. Жанчив. Вагиндра үсгийн дурсгалууд. УБ., 2010 он

¹⁰ 이 상 군, 몽골 문자의 변천과 영향관계 고찰, "몽골 학 Mongolian Studies" 한국몽골학회, Seoul, 1993 (212 pp), 45-67, esp. 60

¹¹ Г. Энхтуул. Монгол бичгийн орхиц үсгүүд. Оюуны хэлхээ, эрдэм шинжилгээний бичиг. Боть 1/08/ УБ., 1912. 195-200-р талд

qoyar keriy-e nisçü yabuḡad nige-yi ben qara gekь гэхэд ийшээ хар, тийшээ хар, энийг хар, тэрийг хар гэхчилэн захирах утгыг сүүлээр

qoyar keriy-e nisçü yabuḡad, nige-yi ben qara gekь гэхэд нэгийгээ харж, хандаж яваарай гэсэн утгыг сүүл таслалаар


qoyar keriy-e nisçü yabuḡad nige-yi ben qaru gekь гэхэд тэр юмыг шүүрч аваад ир гэхийг хүнхэр орхицоор


qoyar keriy-e nisçü yabuḡad nige-yi ben qar-aa gekь! буюу анхааруулан хандуулах утгыг титэмтэй цацлагаар илэрхийлэн бичиж илтгэдэг монгол бичгийн бичвэрийн онцлогт орхиц үсгийн үүрэг үлэмж онцгой байдаг гэж орхиц үсгийн утгын үүргийг нарийн ажиглан тодорхойлжээ.

§4. Вагиндр үсгээр бичих горим Бага насны анхан сурах багачуудад хандаад эх хэл аялгууных нь аман дуудлагын авиалбарыг тэмдэглэх зориулалттай тул монгол бичгийн гурван газар ордог олон хувилбар дүрсийг хурааж, дунд ордог хэлбэрүүдийг сонгон, үг бүтээврийн утга ялгарах авиалбар тэмдэглэсэн шинэ үсгүүдийг зохиож эхэнд бичих а-гийн титмийг үлдээгээд, бусдыг нь хурааж, адагт орох сүүл, цацлага, орхицыг мөн хурааж, дунд бичдэг хэлбэрээр тэмдэглэхээр тогтоожээ.


§5. Бичих горимыг зэрэгцүүлж жишээлбэл:


Ацагт (а, на, та, ла, ха, үа) үсгийн жишээ:


Мо.  Ba  9:01:02: /алтан/

Мо.  Ba  3:24:21: /наран/


Мо.  Ba  5:09:25: /мал/


Мо.  Ba  5:05:30 /лавай/


Мо.  Ba  09:06:10: /хад/


Мо.  Ba  12:02:03: /газар/


Шилбэт (i, ya, wa, ra, ja, ha) үсгийн жишээ:


Мо.  Ba  3:08:02: /итгэл/


Мо.  Ba  3:08:21: /жаргал/

Мо.  Ba  3:30:03: /эсон/


Мо.  Ba  5:05:09: /очирт/


Мо.  Ba  5:02:27: /рашаан/


Мо.  Ba  6:06:06: /дуудаж/



Мо.  Ba  4:33:11: /лхарамба/

Гэдэст (о, и, ө, ү, ба, ра, та) үсгийн жишээ

Мо.  Ba  3:03:01: /орон/


Мо.  Ba  10:12:10: /улаан/

Мо.  Ba  12:10:08: /өргөн/

Мо.  Ba  8:02:01: /үтэр/

Мо.  Ba  8:22:19: /байв/


Мо.  Ba  3:00:07: /Петербург/


Мо.  Ba  5:06:15: /таван/


Эрүү завжин (ca, ča, ja, sa, ša) үсгийн жишээ

Мо.  Ba  5:17:04: /цааз/


Мо.  Ba  5:03:12: /чадал/

Мо.  Ba  5:21: /заларч/


Мо.  Ba  3:24:21: /сэтгэл/


Мо.  Ba  3:24:21: /шулмас/


§6. Нэмж зохиосон (e, ё, и, й, ž, с, h) үсэгтэй жишээ


Ba  6:02:10: Мо  /өөрийн/

Ba  6:03:13: Мо  /эгшинг/

Ba  6:11:02: Мо  /усан/

Ba  6:02:05: Мо  /үсэг/

Ba  6:25:11: Мо  /жил/

Ba  6:07:02: Мо  /чанарыг/

Ba  6:02:26: Мо  /сайхан/

Жишээлж зэрэгцүүлбэл монгол бичгийн зурмын хувилбар олон, холбоц нь өөр байна. Вагиндра үсэг гол авиалбараа тэмдэглэсэн үсэгтэй, холбоц нь шулуун байна.

§7. Монгол бичгийн урт эгшгийн холбоц Монгол бичгээр урт эгшгийг тэмдэглэхдээ богино урт эгшгийн хооронд ү, г, у, б, т гийгүүдэгчээр уртатган тэмдэглэх ба хоёр эгшгийг давхарлах хийгээд богино эгшгээр бичээд, уртатган дуудах үндсэн гурван аргатай. Жишээ нь:

- | | |
|--|--|
| 1. aγarča  аарц, | egejegei  ээжгий |
| jīγaburi  заавар, | jigeli  зээл |
| čigig  чийг, | toγuγači  тогооч |
| oγusur  оосор, | ögekü  өөх |
| aγuljaburi  уулзвар, | egürge  үүрэг |
| uγuta  уут, | čiyulγan  чуулган |
| ügüče  үүц, | sigüsü  шүүс |
| qaburjiγ-a  хаваржаа, | üniyečün  үнээчин |
| büriγ-e  бүрээ, | debel  дээл |
| kömün  хүүн (хүн) | |
| 2. qauli  хууль, | teüke  түүх |
| toγuγu  тойруу, | bilü  билүү |
| boubu  боов, | ouγan  ууган |
| kököür  хөхүүр, | kögerüü  хөөрүү |
| 3. abu  аав, | eji  ээж |
| ši  ший, | šo  шоо |
| uγγ-a  уурга, | mögü  мөөг |
| bübei  бүүвэй гэх мэт | |

§8. Вагиндра үсгийн урт эгшгийн холбоц

Агваан хамбын туурвисан "Шинэ хуучин үсгүүдийн ялгал тэргүүтнийг бичсэн дэвтэр оршив" гэдэг номын II дүгээр хуудсанд урт эгшгийн холбоцыг

аа , ээ , оо , уу , өө , үү хэмээн эгшиг үсгийг давхарлан бичихээр тогтоосон байна. Жишээ нь:

аа аяар яв, аа аарц уу, аа аадар бороо, аа ээлтэй өлзий, аа ээзгий ааруул, аа ийм тийм, аа ийш, тийш, аа оодон сүүлтэй, аа уужим навч /далбагар навч/, аа уут сав, аа уужим гэр, аа өөдөө болох, аа өөрийн чадал, аа үүд өрх, аа үүл манан гэх мэт.

Урт эгшгийг тэмдэглэх өөр нэгэн хувилбар нь: "Буриад хөөр" хэмээх аман зохиолын эмхтгэлийн "шинэ үсгийн учир" гэсэн хэсэгт "Эгшиг үзүг утаар дуулдажи болхо юмэ. Тиймэ үзүг ута гэжи мэдэхүйн түлөө аро биедэн бишайхан зурагаар эймэ

(ā, ō, u) тэмдэг хэхү ёһотой. Энэ болбол утайн тэмдэг гэши" гэж урт эгшгийг дулаар тэмдэглэж, богино эгшгээс ялгаж байжээ. Жишээ нь:

аа: аарцны (3:25:08), амаа ангайгаад (3:15:12)

ээ: ээл хишиг (3:22:15), эцэст (3:9:2)

ии: эзэгтэй (3:22:15)

оо: оомол загастай (3:23:03), олноороо (3:11:18)

уу: ууж (3:25:08), унтуулав (3:15:12)

өө: өөд (3:05:21), өөрөө (3:10:06)

үү: үүд (3:22:16), өгсү би (3:14:10)

§9. Монгол бичгийн амин үсгийн холбоц

Дан гийгүүлэгч (ТТ. 36. 22)-ийг амь залгагч (ТТ. 13a16, ХҮ3a21), эгшгээр амь өгсөн (ТТ. 13a. 21), амь оруулсан (ОБС 76 16) дүрийг (ТТ. 4a1) амьтай үсэг (БТБ. 521) хэмээн нэрлэсэн бөгөөд дан гийгүүлэгч эгшгээр амь орсон үсэг (ТТ. 21a27) болох тул хэлэхүйн үе болон бүтэв хэмээн үзэж амин үсэг гэж нэрлэжээ. Амин үсэг гэдэг нэр томъёо төвд хэлний зүйн бичгүүдээс уламжлалтай гэдгийг эрдэмтэд нотолсон. (44:71) Төвд хэлний цагаан толгойн А үсгийг 'srog gi yi ge буюу амин үсэг гэдэг. (4:43) Энэхүү ойлголт нь Энэтхэг - Төвдийн уламжлалт хэлшинжлэлийн тулгуур зарчим болох урау-грайна буюу арга билгийн зарчмаар хэлний үзэгдлийг тайлбарлахад хэрэглэж байсны нэгэн жишээ юм. Тухайлбал, хэлний авиаг эгшиг гийгүүлэгч гэж ангилахад тэдгээрийн бие биенээ нөхцөлдүүлсэн нэг нь нөгөөгүйгээр эс ор пих мөн чанарыг илтгэж эгшгийн тухайд гийгүүлэгчийн, гийгүүлэгчийн тухайд эгшгийн үүрэг гүйцэтгэх хоёрдмол шинжтэй, эгшиг гийгүүлэгчийн хоорондох харьцааны амин сүнс болсон бичлэгийн махбодыг амин үсэг гэж нэрлэсэн байна. (38:124)

Уях холбоц

Холбох холбоц

Зангидах холбои

Дагуулах холбои:

§10. Вагиндра бичгийн амин үсгийн холбоц

Агваан хамбын туурвисан "Шинэ хуучин үсгүүдийн ялгал тэргүүтнийг бичсэн дэвтэр оршив" хэмээх хэлзүйн бичгийн 8,9-р хуудсанд долоон эгшгээр амилсан амин үсгийг ийн хэмээн тэмдэглэжээ.

- 15 -

1 (a) úsúg geygülegčiyñ amindo oroxoni

ʔ (ga) ʔ (xa) ʔ (za) ʔ (ča) ʔ (ña) ʔ (da) ʔ (ta) ʔ (na)
 ʔ (ba) ʔ (pa) ʔ (ma) ʔ (za) ʔ (ca) ʔ (va) ʔ (ča) ʔ (ša) ʔ (ya)
 ʔ (ra) ʔ (la) ʔ (ha)

1 (e) úsúg geygülegčiyñ amindo orxoni

ʔ (ge) ʔ (xe) ʔ (žc) ʔ (če) ʔ (ñe) ʔ (de) ʔ (te) ʔ (ne)
 ʔ (be) ʔ (pe) ʔ (me) ʔ (ze) ʔ (če) ʔ (ve) ʔ (še) ʔ (se) ʔ (ye)
 ʔ (re) ʔ (le) ʔ (he)

egesig 1 (i) oruqui anu.

ʔ (gi) ʔ (xi) ʔ (ži) ʔ (či) ʔ (ñi) ʔ (di) ʔ (ti) ʔ (ni)
 ʔ (bi) ʔ (pi) ʔ (mi) ʔ (zi) ʔ (ci) ʔ (vi) ʔ (ši) ʔ (si) ʔ (yi)
 ʔ (ri) ʔ (li) ʔ (hi)

ʔ (o) egesig oruqui anu:

ʔ (go) ʔ (xo) ʔ (zo) ʔ (čo) ʔ (ño) ʔ (do) ʔ (to) ʔ (no)
 ʔ (bo) ʔ (po) ʔ (mo) ʔ (zo) ʔ (co) ʔ (vo) ʔ (šo) ʔ (so) ʔ (yo)
 ʔ (ro) ʔ (lo) ʔ (ho)

ʔ (u) egesig oruqui anu:

ʔ (gu) ʔ (xu) ʔ (žu) ʔ (ču) ʔ (ñu) ʔ (du) ʔ (tu) ʔ (nu)
 ʔ (bu) ʔ (pu) ʔ (mu) ʔ (zu) ʔ (cu) ʔ (vu) ʔ (šu) ʔ (su) ʔ (yu)
 ʔ (ru) ʔ (lu) ʔ (hu)

ʔ (ö) egesig oruqui anu

ʔ (gó) ʔ (xó) ʔ (žó) ʔ (čó) ʔ (ñó) ʔ (dó) ʔ (tó) ʔ (nó)
 ʔ (bó) ʔ (pó) ʔ (mó) ʔ (zó) ʔ (có) ʔ (vó) ʔ (šó) ʔ (só) ʔ (yó)
 ʔ (ró) ʔ (ló) ʔ (hó)

ʔ (ü) egesig oruqui anu

ʔ (gü) ʔ (xü) ʔ (žü) ʔ (čü) ʔ (ñü) ʔ (dÜ) ʔ (tü) ʔ (nü)
 ʔ (bü) ʔ (pü) ʔ (mü) ʔ (zü) ʔ (cü) ʔ (vü) ʔ (šü) ʔ (sü) ʔ (yü)
 ʔ (rü) ʔ (lü) ʔ (hü)

Эдгээр үсгүүдийг холбосон нэрийн жишээ:

ᠪᠠᠷᠠᠨ baran 3:01:09 (хамаг, бүгд, цөм, хуу, цаглашгүй)

ᠪᠡᠳᠡᠷᠵᠢ bederži 3:14:09 (эрж, хайж, бэдэрч)

ᠪᠢᠰᠠᠶᠬᠠᠨ bišayхан 3:28:10 (бяцхан, жижигхэн)

ᠭᠡᠨᠦᠰ genüš 3:19:11 (гэнэ үү чи?)

ᠭᠢᠨᠳᠡᠨᠭᠠᠰ gindenhē 5:17:11 (гяндангаас),

ᠭᠢᠷᠳᠢᠭ kerdig 3:05:04 (гарьд)

ᠬᠢᠷᠡ kirē 3:14:01 (хэрээ),

ᠠᠳᠠᠬᠠ adaha 3:22:14 (адуу)

ᠡᠯᠭᠡ ᠡlge 3:22:15 (ээл хишиг)

ᠢᠵᠢ izi 3:20:07 (ээгтэй)

ᠣᠳᠣᠭᠣᠨ od'ogon 3:25:17 (удган)

ᠤᠷᠠᠶᠤ ur'ay 3:01:03 (урьд)

ᠥᠷᠦᠭᠦ ᠥryō 3:18:03 (өөрийнхөө)

ᠦᠯᠭᠦᠨ ülgün 3:05:11 (өлгөн дэлхий)

ᠶᠠᠵᠠ yazā 3:03:05 (гадаа)

ᠭᠣᠷᠢᠬᠣᠨ gorixon 3:05:04 (горхи)

ᠭᠤᠨᠠᠨ gunan 3:26:03 (гунан)

ᠭᠦᠳᠡᠬᠡ güdehe 3:16:02 (гэдэс)

ᠬᠠᠳᠬᠠᠳᠬ'ᠣᠪᠠ xadxādx'oba 3:04:08 (хатгаад орхив)

ᠬᠣᠲᠣᠭᠣ хот'ogo 3:17:07 (хутга)

ᠬᠤᠬᠠᠨ ...xuhan 3:25:20 (хус)

ᠬᠣᠷᠬᠣᠶᠤ kōrkōy 5:17:07 (хөөрхий)

ᠬᠦᠳᠦᠢ күдүй 3:13:06 (хэдий)

ᠠᠨᠬᠠᠨ anхан 6:00:04 (анхан)

ᠵᠢᠷᠬᠡᠮᠦᠢ žirkemüi 3:08:01 (жирхмүй, зэвүүцнэ)

ᠴᠠᠷᠬᠠ cārho 3:20:11 (цаас)

ᠨᠠᠯᠳᠦᠯᠵᠢᠬ'ᠣᠳ nāldülžix'ōd 3:19:06 (наалдуулчихаад)

ᠳᠠᠯᠢ dali 3:23:11 (далавч)

ᠲᠦᠬᠤᠷ'ᠣᠨ түкүр'өн 3:29:11 (төгрөг)

ᠨᠠᠮᠰᠢᠬᠠᠨ namšihan 3:25:01 (навч)

ᠪᠣᠬᠣᠶᠠ boxoya 3:02:12 (босго)

ᠪᠤᠷ'ᠠᠰᠢ bur'āši 3:20:05 (буриадыг)

ᠪᠣᠲᠦ bō 3:22:06 (бөө)

ᠪᠦᠲᠦ бүтү 3:04:15 (мэт)

ᠫᠦᠳᠦ pūd 3:06:01 (пүү)

ᠮᠠᠩᠶᠠᠯᠠ manyilay 3:25:02 (магнай)

عزىلاباي zuyālabay 3:27:08 (хэлэв)

عارجا cārgo 3:20:06 (цаарга)

وارناسى varanasi 5:05:26 (Варнааш хот)

چىڭنۇر śīñnūr 3:26:06 (чигнүүр, жинлүүр)

سۆھۆ sōhō 3:26:06 (дотроос)

يۈھۈڭ yühün 3:29:19 (ес)

راشان raśān 5:02:27 (рашаан)

لوساي losay 5:11:25 (лусын)

ھامايان hamayaṅ 3:19:19 (самган, эхнэр, гэргий)

ھەلبە helbē 3:21:17 (сэлбээ)

ھومو homo 3:25:06 (сум)

ھۇخادە huxādā 3:05:10 (суухдаа)

ھۈكە hūke 3:19:07 (сүх) гэх мэт.

§11. Дэвсгэр үсгийн холбоц

"Арван нэгэн толгой үсгүүд na, ba, ya, ma, la, ga, sa, da, ya, wa үсэг хийгээд эдгээрийн дээр ng нэмээд арван нэгэн үсгийг дэвсгэрийн үсэг хэмээмүй" гэж Агваандандар лхарамба "Хэлний чимэг" хэмээх хэлзүйн бичигтээ тодорхойлжээ. Академич Б.Ринчен "Дэвсгэр үсэг гэж монгол үгнээ үеийн адгийн гийгүүлэгч буюу бидний одоогийн нэр томъёогоор битүү үеийн адгийн гийгүүлэгч гэдгийг нэрлэх бөгөөд монгол үсгийн зөв бичих ёсноо тэр дэвсгэр үсэг нэн чухал болох тул цагаан толгойд түүнийг заадаг нь зөв бичих ёсны гол зарчмын нэг нь байжээ. (30:76) гэж тайлбарласан байна.

Монгол хэлзүйн дурсгалт бичгүүдэд монгол бичгийн дэвсгэрлэх ёсны талаар дэлгэрэнгүй номлосон байдаг бөгөөд арван нэгэн дэвсгэр үсгийг амин үсгийн холбоц болгож зах шүтэгч (ТТ22а3) үсэг хэмээн нэрлэдэг уламжлалтай байжээ. Зах шүтэгч үсэг гэдэг нь одоогийн ойлголтоор үсгийн зааг, үгийн адгийн гийгүүлэгчийг нэрлэдэг.

Зах шүтэгч буюу дэвсгэрлэх ёсны уламжлал вагиндра үсэгт уламжилсан боловч нөхцөлийг дагуулалгүйгээр залгаж бичдэг тул зах шүтэгч үсэг хэмээх ойлголт нөхцөлөөр хэлбэржсэн үгийн хувьд үеийн заагт тохиолдох болжээ.

Дэвсгэр үсгийн холбоцыг вагиндра үсгээр бичсэн жишээгээр үлгэрлэвэл:

ende ەندە (3:22:17)

bāhayn ەباھەين (3:16:02)


abxo ەبوھۆ (3:23:21)

idebeb ەئىدەبەب (3:13:15)

bagtaži ەباگتاژى (3:15:08)


bulag ەبۇلاگ (3:21:01)


ñimgen  (3:20:11)

boltayay  (3:23:20)

yarhan  (3:23:15)

alostā  (3:08:21)

tēdkeyken  (3:01:03)

tüymür  (3:22:03)

manγadxay  (3:03:09)

ulam  (3:08:09)

γal  (3:06:21)

γazar  (3:22:13)

oros  (3:27:01)

manγad  (3:17:08)

manyilay  (3:25:02)

ñüdün  (3:26:15)

§12. Шинэ үсэг зохиох болсон шалтгаанаа "Шинэ хуучин үсгүүдийн ялгал тэргүүтнийг бичсэн дэвтэр оршив" хэмээх бүтээлдээ Агваан хамба дурдахдаа: "Манай монгол үсэг болвоос ямагт дүрс үзэсгэлэн ба бичихэд амрыг таалъяу. Дээр доор орохдоо олонтоо хувилах, олон шүд болгож тоолохын зовлонгоор анхан үсэг танихад маш бэрх. Арайхан үсэг холбож танивч урьд цагийн амьтны мартагдсан хэл ба үсэгтээ хашигдаж, хаа газрын хэн ч үл хэлдэг үг бичих нь анх бичиг сурахад харь хэлнээс орчуулсан лугаа адилаар сурмуй. Бичихдээ ч өөрийн хэлээ бус хэл болгож урвуулан бичмүй. Зүгээр гагцхүү энэ үсэг нь эрхлэн сурваас сайтар сурах боловч энэ цагт бус хэлний сургуулийг хичээлгүй аргагүй тул өөрийн хэлний үсгийг таньж ядсаар танивч Дээдэс богд нарын зуун алжаалаар орчуулан хэвлэсэн ба бичсэн судар шастурууд шүтээн төдий болох нь ойртвой. Тэр тул танихуйд амар шинэ үсгээр сурч, түргэн уншиж хэлээрээ бичиж сурваас өөрийн хэл хожимдохгүйн дээр хуучин шинэ үсгийн дохио зохиовоос түүгээр цаг зуур хуучнаа таних болмуй. Танихуй амар шинэ үсэг нь хорин найман үсэг бөгөөд эдгээрийг тогтоовоос саадгүй бичиг дуудмой. Өөрийн хэлээр ч саадгүй бичиж болмуй. Учир нь дээр доор орохдоо дүрс хувилалгүй хэв янзаар бичигдэх тул билиг хэдий мохдог боловч ахархан цагт үсэг таних болмуй. Хаа газрын монгол улсын хэл дохио үгийг тэр хэвээр бичихэд амраар үл барам, харь хэлийг ч тэмдэг тавиад бичихэд маш хялбар болой"¹³ хэмээн учирлан бичсэн байна.

Мэхийж санаваас, Агваан хамбатан анхан сурах багачуудад зориулж сурахад хялбар нэгэн шинэ бичгийн тогтолцоог монгол бичгийн зурлага дээр суурилан буй болгохыг зорьжээ. Гэхдээ энэ бичгээ зөвхөн буриадад бус нийт монгол үндэстэнд зориулсан болох нь дээр өгүүлснээс тов тодорхой байна.

Агваан хамба шинэ үсэг зохиох болсон шалтгаанаа "Буриад шинэ үсэгт тааруулсан зүрхэн тольт гэж эхлэгдсэн анхан дэвтэр оршив" хэмээх бүтээлдээ:

"Өөри хэлээр бичиж болхо бэрхэ дээрhээ зориг хухаражи орхиж орхидог олон. Тиимэ тулада *hургуулитанари заабаряар э, ө, у, ү, ж, ч үзэги дүрсэ ондоо болгоод h үзэг нэмэжи дээрэ, дооро, дунда орходоо дүрсэ хубилха үгүй хэбээрэ табигдаха. Ямарши хэлээр бишижи болхо, хэдүй тэмдэг табяад хуушин монгол үзэг мэдэхэйн шата гэххүүр болхо аргада дохёо бичиг даяг /словарь/ хигдэмой"*¹⁴ хэмээн бичсэнээс үзэхэд бага насны хүүхдэд монгол бичиг үзүүлнэ гэхэд нутаг нутгийн аялгуу аман хэлээр хэлд орсон хүүхэд гадаад хэл сурч байгаа мэт бэрхшээлтэй учир шинэ бичгээр анхан сурах багачуудыг амлаж, аман дуудлага тэмдэглэх шат болгоод, үсэгт тайлагдаад, уншиж бичиж цагаашраад ирэхээр нь монгол бичиг номын хэлээр хадмал толь бичиг үйлдэж, монгол

¹³ Vāgindra, Sine qaučín üsüg- ьд- ün ilyal terigŷten-I bičigsen debter orosiba, 16 тал

¹⁴ Bur'ad sine üzügtü tärülhan zürnen tolto geži exilegdehen aŷhan debter orošibay, Санктпетербург, 1908, 27 тал

бичиг судрын хэлэнд хөтлөн оруулах нь зүйтэй байна хэмээн үзээд, шинэ үсэг зохиож, монгол түмний хүүхдийг умар зүгээс нь эхлэн бурхан багшийн нарны гэгээн туяагаар гийгүүлэн (17:51) гэгээрүүлэх их үйлсийн үрийг суулгажээ.

Цанид хамба Агваан лхарамбатан шинэ үсэг зохиохдоо уламжлалт монгол бичгийг зурлага холбоцын хувьд өөрчлөн хувиргаж, төгөлдөр боловсронгуй болгон шинэчилж, хуучин монгол бичиг хэмээн нэрлээд, халж өөрчлөх санаа агуулсангүй, харин сонгодог монгол ном судрын хэлний их далайд цутгах олон салаа гол горхи, мөрөн мэт нутаг нутгийн амьд хэл аялгуунаасаа эхлэн зорчих хөлөг болсон вагиндра үсгийн зурам зурлага, бичгийн холбоцуудыг хялбарчлан бүтээж, суу билигт судар бичгийн хэлэнд цагаашрах анх мөрийг тавьж өгчээ хэмээн дүгнэх нь зүйд нийцтэй болов уу.

НОМЗҮЙ

1. Агваан Доржиев, Занимательные заметки: Описание путешествия вокруг света /Автобиография/, Факсимиле рукописи, Перевод с монгольского А. Д. Цендиной. Транслитерация, предисловие, комментарий, глоссарий и указатели А. Г. Сазыкина и А. Д. Цендиной, "Памятники письменности востока СХХХIII", М., 2003, 160сс
2. Амагаевъ Н. и Аламжи-Мэргэнъ, Новый монголо-бурятский алфавить, Спб, 1910, 51сс
3. БТБ - Галсан. Монгол үсгийн бүгд тайлбар бичиг. ӨМАХХ. Хөх хот. 1981
4. С. Б. Бадараев. Об основах транскрипции и транслитерации для тибетского языка. Улан-Удэ 1967
5. Жалайр Батбаяр, Монгол уран бичлэгийн түүх, Тэргүүн дэвтэр, УБ., 2001. 275 тал
6. Ж. Баянсан, Ш. Одонтөр, Хэлшинжлэлийн нэр томъёоны зүйлчилсэн тайлбар толь. УБ., 1995. 314 тал
7. Bousiyang, Mongyol ьсыг bičig-ын идаган, ӨМАХХ., 1998. 222 тал
8. Bulay, Mongyol ьсыг bičig-ын tobči teke, ӨМАХХ, Хөх хот., 1983., 296 тал
9. Bo. Bulay, Vagindr-a üsüg, Mongyol sudulul-un neberkei toli. Üge kele üsüg bičig, Encyclopaedia of Mongol Studies. ӨМАХХ, 2004. 12 сар, 836 тал
10. Буриадын Агваандоржийн намтар. Шинэ үсэг, латин галигт буулгаж монгол төвд эхийг хавсаргасан/ Хэвлэлд бэлтгэсэн Р. Бямбаа, Г. Гантогтох "Лавайн эгшиг". , 2001, №1, 130 тал
11. Гантогтох Г. Зүрхэн толт хэмээх хэлзүйн бичиг ХЗС 19-р зуун. 2. УБ., 1987. 14-19
12. Гантогтох Г. Вагиндрагийн үсэг хийгээд тод монгол үсгийн дүнцүүлэл // Хэл ба орчуулга. Үрүмчи 1991. №3/23/ 27-83
13. Г. Гантогтох. Вагиндра үсэг, "Алтаргана -4, Буриад -Монголчуудын угсаа түүхийн зарим асуудал", Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэл, хэлсэн үг" УБ., 2000, 200-215-р тал
14. Г. Гантогтох. Вагиндрагийн бичиг. Монголын нэвтэрхий толь. Монгол улсын шинжлэх ухааны академи. УБ., 2000. х 208-209
15. Г. Гантогтох. Вагиндра үсэг. "Төв Азийн нүүдэлчдийн бичиг үсгийн товчоон", УБ., 2001. /328-р тал/, 305-328
16. Г. Гантогтох. Вагиндрын үсэг. Дашбалбар Дашибалбарайхин. УБ., 2005, 47-р тал
17. Г. Гантогтох. Бурхан багшийн нургаал буряад вагиндра үзэгээр. Мир буддийской культуры: Наследие и современность. Материалы 3 Международного симпозиума. 3-5 ноября 2010 г. Чита - Агинское с. 47-51

18. Гантогтох. Г. Вагиндрын үсгийн авиалбарын тогтолцоо. Оюуны хэлхээ /эрдэм шинжилгээний бичиг. Боть 1-06/, 2010, 174-204 тал
19. Г. Гантогтох. Айдурай мэргэн Антоон Мостаэрт монгол судлалын төв. Monograph series volume 1. Эрхэлсэн Г. Цэцэгдарь. УБ. , 2009. /260 тал/ Вагиндра үсгийн эх. 67-129-р талд
20. Г. Гантогтох. Хараасгай мэргэн Антоон Мостаэрт монгол судлалын төв. Monograph series volume 3. Эрхэлсэн Г. Цэцэгдарь. УБ. , 2010. /254 тал/ Вагиндра үсгийн эх. 71-122-р талд
21. Гомбо - Намжил Заяатуе Цанид хамба Доржиев /1853-1938/, Улан-Үдэ. 1998
22. Ц. Дорж. Цанид хамба Агваан Доржиев, "Улаанбаатар" сонин. 1993. 05. 20. №95
23. Д. Н. Доржиев, Об орфографии старобурятского письма. "Филологический сборник", Памяти Б. Ц. Найдакова, РАН, Сибирское отделение. Бурятский научный центр Института Монголоведения, буддологии и тибетологии, Улан-Удэ, 1998
24. Дэлхийг эргэж бядсан домог сонирхлын бичиг төдий хэмээх "Алтан хүрдэн". Хэвлэлд бэлтгэсэн Л. Хүрэлбаатар. УБ. , 1992, 103-128-р тал
25. Ё. Жанчив. Вагиндрын үсэг. Acta Historica, Acta Historica Mongolici, МУБИС. Т8. 1-23 тал. УБ. , 2007. 162 тал, 76-87-р тал
26. Ё. Жанчив. Вангидра үсгийн дурсгалууд. УБ. , 2010 он
27. Д. Кара, Книги монгольских кочевников, М. , 1972, 194 тал, 26-р талд
28. Н. Очирбат. Үсгийн урлаг. УБ. , 2000, 300 тал
29. ОБС - Тогтохтөр ван Блама өгүүлэхүйн арслан Манзушири эгши гт эхэд мөргөж, Монголын зуун хорин гурван цагаан толгой үсгийг туурвисан Оюун билгийн соёрхол хэмээгч оршивой. Модон бар. 1984 он. 14 хуудас
30. Ринчен. Монгол бичгийн хэлний зүй, Тэргүүн дэвтэр, удиртгал. УБ. , 1964. х76. 172-175 тал
31. Г. Д. Санжеев, Семь лет у Б. Я. Владимирцова, "Российское монголоведение" Бюллетень 4, М. , 1996. 203 сс
32. Докторант Соёлмаа. Вагиндра үсэг болон түүний сурвалж бичгийн судалгаа. Тэргүүн дэвтэр. 202-650 тал. Бээжин 2012 оны 3 сар. /Доктор цол хамгаалсан материал/
33. Sečenbayatur, Ayvang kiged tegьn-ь jokiyaьsan Vagindr-a ьсьг-ьн tuqai, "Mongyol kele bičig", 1995. №6, 60-63, 44
34. Т. Т. Лувсанринчен. /Сумадирадна/ Монгол үсгийн ялгалыг үзүүлэгч Тодорхой толь нэрт оршивой. Буриад модон бар. 1872 он. 37 -р тал.
35. Tulyayuri, Mongyol ьсьг bičig-ьн теькен toyimu, ӨМСХХ, 1998. 417 тал, 248, 251-255 дугаар тал
36. ХҮ-Агваандандар лхамрамба Монгол үсгийн ёсыг сайтар номлосон хэлний чимэг хэмээгдэх оршивой. Буриад модон бар. 1828 он. 10 хуудас
37. Ж. Цолоо, Вагиндрагийн Буриад монголын бичгийн үсэг зүй //Орчин цагийн монгол хэлний авиа зүй. Нэмж засварласан 2-р хэвлэл. УБ. , 2008 он. 141-146 р тал.
38. Д. Цэрэнпил "Зүрхний тольтын тайлбар" дахь амин үсгийн тухай ойлголт. //МУИС. Монгол хэл соёлын сургууль. Монгол судлал. ЭБШ. 27-р боть. 13-р дэвтэр. УБ. , 2007. хуудас 122-130
39. Ш. Чоймаа. Вагиндрын үсэг. , "Үнэн" 1991. 01. 08.
40. Ш. Чоймаа. Монгол судлалын өгүүллүүд. УБ. , 2003, 371 тал
41. Л. Чулуунбаатар, Нүүдэлчин монголчуудын бичиг үсгийн соёл. УБ. , 2002. 250 тал

42. Ц. Шагдарсүрэн. Монгол үсэг зүй. УБ. , 1981. 168 тал
43. Ц. Шагдарсүрэн. Монголчуудын үсэг бичгийн товчоон. УБ. , 2001. 300 тал
44. Г. Энхтуул. 19-р зууны уламжлалт монгол хэлшинжлэлийн сэтгэлгээний хөгжил // Хэлшинжлэлийн ухааны доктор (Ph. D) -ын зэрэг горилсон ганц сэдэвт зохиол. УБ. , 2013. х 71-72
45. Г. Энхтуул. Монгол бичгийн орхиц үсгүүд. //Оюуны хэлхээ, эрдэм шинжилгээний бичиг. Боть 1/08/ УБ. , 1912. 195-200-р талд
46. John Snelling, Buddhism in Russia, The Story of Agvan Dorzhiev, Lhasa s Emissary to The Tsar, Shaftesbury, Dorset
47. Yeshen-khorlo, Dugarova-Montgomery, Robert Montgomery, "The Buryat Alphabet of Agvan Dorzhiev", Bloomington, Indiana.
48. The Buryat Alphabet, "The World's Writing Systems", Edited by Peter. T. Daniels and William Bright, New York, Oxford, Oxford University Press, 1996
49. Gyorgy Kara, Books of the Mongolian Nomads, More than Eighth Centuries of Writing Mongolian, First English Edition, Translated from the Russian by John,
50. R. Krueger, Indiana University, Bloomington, Research Institute for Inner Asian Studies, 2005. Y-IX+331 pp. +XXXVII plates
51. 이 성 균, 동골 문자의 변천과 영향관계 고찰, "몽골 학 Mongolian Studies" 한국몽골학회, Seoul, 1993 (212 pp). 45-67. esp. 60
52. [匈]Д. 卡拉著, 范丽君译, 乔吉审订, 蒙古人的文字与书籍, 蒙古历史文化文库, 内蒙古人民出版社, 2004, 241页。
53. [苏]符. 阿. 库德里亚夫采夫、格. 恩. 鲁缅采夫等著, 高文德译: <<布里亚特蒙古使>> (下册), 中国社会科学院民族研究所社会历史研究室, 第93页。
54. [匈牙利]Д. 卡拉著, 范丽君译: <<蒙古人的文字与书籍>>, 内蒙古人民出版社, 2005, 第0页。
55. 荒井幸康「言語」の統語と分離、三元社、2006、[42-43]。

SUMMARY

Vagindra script and Mongolian script links

This article entitled 'Vagindra script and Mongolian script links' determines that Agvaan Dorjiev (1854-1938) from Buriyat designed a new script in 1905 through adapting the Mongolian script forms to the spoken dialect. Moreover, it provides the list of 12 manuscript monuments written in Vagindra script which have been found in scientific studies so far. It also refers to the research works by Yo. Janchiv (2010) and Soyolmaa (2012) who studied these monuments, provided their transcription and translation and published their studies depicting the photos of the original monuments.

This article takes examples by writing linking forms for letters with the forms such as *atsag*, *shilbe*, *gedes*, *eruu*, and *zavji*. It also shows more examples of linking forms for long vowels of the Mongolian script and the Vagindra script and the linking method of the consonants and vowels of the both scripts. This article made a conclusion that Agvaan Dorjiev didn't intend to make changes in traditional forms of the Mongolian script in order to improve or reform it when he created this new script, Vagindra but he aimed to clarify the forms of script and simplify its links in order to help early learners to learn the classic Mongolian script easily first by reading their dialect in Vagindra and then the classic script.

Key words: script, Vagindra, linking forms, Mongolian script, dialect, monument